



“АДУУНЧУЛУУН” ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2024 оны 07 сарын 31 өдөр

Дугаар 21/11

Чойбалсан хот

Төлөөлөн удирдах зөвлөлийн даргыг  
сонгох тухай

Монгол улсын Компанийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.1, “Адуунчулуун” ХК-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.30 дахь заалт, Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн (цаашид “ТУЗ” гэх) Үйл ажиллагааны журмын 7 дугаар зүйлийн 7.1, 7.3 дахь заалт, ТУЗ-ийн 2024 оны 07 дугаар сарын 31-ний өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн даргаар Цогтсайханы Шижир улируулан сонгосугай.
2. Монгол улсын Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, болон бусад холбогдох хууль тогтоомжууд, Компанийн дүрэм, ТУЗ-ийн Үйл ажиллагааны журмыг мөрдөж ажиллахыг ТУЗ-ийн дарга /Ц.Шижир/-т үүрэг болгосугай.
3. ТУЗ-ийн дарга сонгогдсон талаарх мэдээллийг Компанийн болон Монголын хөрөнгийн биржийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлж, Хөрөнгийн биржийн цахим хуудас дахь мэдээлэлд холбогдох өөрчлөлт хийхийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга /А.Оюун-Эрдэнэ/-д үүрэг болгосугай.

ГИШҮҮД:

  
Ш.БАЯСГАЛАН  
С.БАДАРЧ  
Б.БАТСАЙХАН  
Л.БАТМӨНХ  
Ш.ИДЭР  
Б.ГАНХУЯГ  
Б.ЭНХБААТАР  
С.НОМИН-ЭРДЭНЭ



“АДУУНЧУЛУУН” ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2024 оны 07 сарын 31 өдөр

Дугаар... 24/12

Чойбалсан хот

Гүйцэтгэх захирлыг томилох тухай

Монгол улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.8, 83 дугаар зүйлийн 83.3, 83.4, 83.6, 83.8, “Адуунчулуун” ХК-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.32.7 дахь заалт, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2024 оны 07 дугаар сарын 31-ний өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Шатар овогтой Баясгаланг “Адуунчулуун” ХК-ийн Гүйцэтгэх захирлаар Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн олонхын саналаар улируулан томилсугай.
2. Гүйцэтгэх удирдлагатай байгуулах гэрээний нөхцөл, гэрээний хавсралтыг шинэчлэн хянаж Төлөөлөн удирдах зөвлөлийн 08 дугаар сарын хуралд танилцуулж батлуулахыг нэр дэвшүүлэх хороонд даалгасугай.

ДАРГА



Ц.ШИЖИР



## “АДУУНЧУЛУУН” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2024 оны 07 сарын 31 өдөр

Дугаар... 21/13

Чойбалсан хот

### Төлөөлөн Удирдах зөвлөлийн Нарийн бичгийн даргыг томилох тухай

Монгол улсын Компанийн тухай хуулийн 82 дугаар зүйлийн 82.1, “Адуунчулуун” ХК (цаашид “Компани” гэх)-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.53, Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөл (цаашид “ТУЗ” гэх)-ийн Үйл ажиллагааны журмын 2 дугаар зүйлийн 2.5.7, ТУЗ-ийн Даргын 2024 оны 07 дугаар сарын 31-ний өдрийн санал, ТУЗ-ийн 2024 оны 07 дугаар сарын 31-ний өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн нарийн бичгийн даргаар Арсланбатын Оюун-Эрдэнийг улируулан томилсугай.
2. Монгол улсын Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжууд, Компанийн дүрэм, ТУЗ-ийн Үйл ажиллагааны журам, Компанийн холбогдох бусад журмыг мөрдөж ажиллахыг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга /А.Оюун-Эрдэнэ/-д үүрэг болгосугай.
3. ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга томилогдсон талаарх мэдээллийг Компанийн болон Монголын хөрөнгийн биржийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлж, Хөрөнгийн биржийн цахим хуудас дахь мэдээлэлд холбогдох өөрчлөлт хийхийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга /А.Оюун-Эрдэнэ/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ц.ШИЖИР



“АДУУНЧУЛУУН” ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2024 оны 07 сарын 31 өдөр

Дугаар: 24/11

Чойбалсан хот

Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороодын  
бүрэлдэхүүнийг батлах тухай

Монгол улсын Компанийн тухай хуулийн 81 дүгээр зүйлийн 81.2, “Адуунчулуун” ХК (цаашид “Компани” гэх)-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.46, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ” гэх)-ийн Үйл ажиллагааны журмын 2 дугаар зүйлийн 2.5.1, 10 дугаар зүйлийн 10.1, 10.2, 10.3 дахь заалт, ТУЗ-ийн 2024 оны 07 дугаар сарын 31-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороодын бүрэлдэхүүнийг дор дурдсанаар баталсугай. Үүнд:

а. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хороо:

Хорооны дарга: Шатар ИДЭР  
Гишүүд: Сугаржав НОМИН-ЭРДЭНЭ  
Баяндэлгэр ЭНХБААТАР  
Санжаа БАДАРЧ  
Баттогтох БАТСАЙХАН

б. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Аудитын хороо:

Хорооны дарга: Сугаржав НОМИН-ЭРДЭНЭ  
Гишүүд: Баяндэлгэр ЭНХБААТАР  
Шатар ИДЭР  
Санжаа БАДАРЧ  
Баярсайхан ГАНХУЯГ

в. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Цалин, урамшууллын хороо:

Хорооны дарга: Баяндэлгэр ЭНХБААТАР  
Гишүүд: Шатар ИДЭР  
Баярсайхан ГАНХУЯГ  
Санжаа БАДАРЧ  
Шатар БАЯСГАЛАН

2. Монгол улсын Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон холбогдох хууль тогтоомжууд, Компанийн дүрэм, ТУЗ-ийн Үйл ажиллагааны журам, ТУЗ-ийн дэргэдэх хороодын журмуудыг мөрдөж,

хорооны жилийн төлөвлөгөөг ТУЗ-ийн 08 дугаар сарын хуралд танилцуулахыг хороодын дарга, гишүүдэд үүрэг болгосугай.

3. ТУЗ-ийн дэргэдэх хороодын бүрэлдэхүүн томилогдсон талаарх мэдээллийг Компанийн болон Монголын хөрөнгийн биржийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэхийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга /А.Оюун-Эрдэнэ/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ц.ШИЖИР